



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 147

Улаанбаатар хот

Зохион байгуулалтын бүтэц, албан тушаалын
жагсаалтыг батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, 18 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтцийг дор дурдсанаар баталсугай.

- 1.1. Захиргаа, удирдлагын хэлтэс;
- 1.2. Төсөл, хөтөлбөр зохицуулалтын хэлтэс;
- 1.3. Хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны хэлтэс;
- 1.4. Судалгаа, шинжилгээний хэлтэс.

2. “Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын орон тооны дээд хязгаарыг 30 байхаар тогтоосугай.

3. “Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтцийг 1 дүгээр, албан тушаалын жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

4.“Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтэц, албан тушаалын жагсаалт батлагдсантай холбогдуулан Хөдөлмөрийн тухай хууль, холбогдох журамд нийцүүлэн зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг захирал Б.Ерөөлтөд даалгасугай.

5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ


ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ



132001349

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн
~~10~~ дугаар тогтоолын 2 дугаар хавсралт



**“УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН СУДАЛГАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТӨВ”
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН АЛБАН
ТУШААЛЫН ЖАГСААЛТ**

Д/д	Албан тушаал	Орон тоо
Удирдлага		
1	Захирал	1
2	Зөвлөх	1
Нийт		
Нэг. Захиргаа, удирдлагын хэлтэс		
3	Дарга	1
4	Санхүүгийн ажилтан	1
5	Нярав	1
6	Хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтан	1
7	Хуулийн ажилтан	1
8	Бичиг хэрэг, архивын ажилтан	1
9	Хяналт, шинжилгээ, үнэлгээний ажилтан	1
10	Жолооч	1
Нийт		
Хоёр. Төсөл, хөтөлбөр зохицуулалтын хэлтэс		
11	Дарга	1
12	Зохицуулагч	3
13	Мэргэжилтэн	2
Нийт		
Гурав. Хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны хэлтэс		
14	Дарга	1
15	Зохицуулагч	1
16	Мэргэжилтэн	3
17	Олон нийттэй харилцах ажилтан	1
Нийт		
Дөрөв. Судалгаа шинжилгээний хэлтэс		
18	Дарга	1
19	Шинжээч	5
20	Мэдээллийн сан, цахим архивлалт хариуцсан ажилтан	2
Нийт		
НИЙТ ОРОН ТОО		
		30

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн
№2 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

Уур амьстгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төвийн бүтэц (ТӨДААТГ)

